



УВС АЙМАГ  
ТҮРГЭН СУМЫН  
ЗАСАГ ДАРГА

Хавцал, Түргэн сум, Увс аймаг, 85200  
Цахим шуудан: info@turgen.uv.gov.mn  
Цахим хуудас: www.uvs.gov.mn/turgensum

2024. 10. 31 № 1/92

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Мэдэгдэл хүргүүлэх тухай

Манай байгууллагаас зарласан 2024 оны 07-р сарын 27-нд цахим хэлбэрээр зарлагдсан орон нутгийн төсвийн хөрөнгөөр – 38000000 (гучин найман сая) төгрөгөөр санхүүжих, “Сургуулийн тоног төхөөрмөж”-ний материал нийлүүлэх, дугаар: УВАТҮСЗДТГ/20240202040 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, цахим тендерийг 2024 оны 08-р сарын 07-ны өдрийн 10<sup>00</sup> цагт нээлт хийж үнэлгээ хийхэд “Сэтгэмж-Урлахуй” ХХК нь шалгарсаныг мэдэгдлээр хүргүүлсэнд гомдол гарч сангийн яамнаас ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн дахин үнэлгээг 2024 оны 09-р сарын 17-ны өдөр зохион байгуулахад танай “Мишээлт гүн” ХХК-н ирүүлсэн материал нь шаардлагад нийцсэн гэж үзэн шалгаруулсан. Шалгаруулалтад оролцсон “Ай Ти Зон” ХХК-аас гомдол гарсан байна.

1. Тендерийн шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.6.1-д “Үйлдвэрлэгчийн зөвшөөрөл. Гэрээт борлуулагчийн зөвшөөрөл” гэж заасан байна. “Мишээлт гүн” ХХК тендерт Dell брэндийн компьютер нийлүүлэхээр санал ирүүлсэн боловч үйлдвэрлэгчийн зөвшөөрөл, гэрээт борлуулагчийн зөвшөөрөл ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 16.6.1-д заасан шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

2. Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.3 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

3. Түүнчлэн захиалагч тухайн худалдан авах бараа цахим дэлгүүрт байршсан эсэхийг нятглан үзэж хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна” гэж заасныг анхаарах нь зүйтэй байна.

Иймд бид бүх тендерээс татгалзан Сангийн яамнаас ирүүлсэн чиглэлийн дагуу бүх тендерээс татгалзаж байгааг үүгээр мэдэгдэж байна.



Л.БУЯНЖАРГАЛ

D: /Blanka-A4/

8524750048